

2.Холи-Агач-Ховд-400 км. Энэ замыг Үгүйн зам гэж нэрлэдэг байсан. ХХ зууны эхээр Үгүйн замыг нэлээд засварлаж сайжруулсан боловч уулархаг газар учраас тээвэрт нэлээн хүндрэл учруулж байв.

3. Белопарск /Одоогийн Туваагийн нийслэл Кизил хот / -Харилцаг -Улиастай-700 км. Энэ нь тэр үедээ шинэ зам байсан юм. Улиастай, Енисейг холбосон энэ зам ачаа тээвэрлэхэд нэлээн хөнгөн байжээ. Энэ замын үргэлжлэл нь Белоцарск-Минусинск-Красноярск ордог.

4.Монд-Хатгал-Улиастай-600 км. Энэ замын үргэлжлэл нь Монд-Түнхэн-Култун-Иркутск ордог байжээ. Ойролцоогоор 400 км. Түнхэн Хатгалын хоорондох зам маш хэцүү байсан. Харин Хатгалаас Улиастай хүрэх зам арай дээр байжээ.

5.Хиагт-Өргөө-350 км. Энэ замын үргэлжлэл нь одоогийн Улаан-Үд гол ба өвөлдөө Сэлэнгийн мөсөн дээгүүр, зундаа усан онгоцоор гаталж байжээ. Хиагт-Өргөөгийн зам нь муу биш, гол хүндрэл нь Манхтайн намагтай газар таардаг учраас тойрч гарах явдал юм.

6.Манжуур-Өргөө-1000 км. Энэ нь тэмээн жинд тохиромжтой сайн зам юм. Өргөөгөөс 200 км газар Зүүн хүрээний ойролцоо Хэрлэн голыг дайран Бэрээвэн хийдийн хажуугаар Улз гол ордог энэ зам нь 450 км үргэлжилсэн бөгөөд нэг ч уул нуруу дамжилгүйгээр Манжуур ордог автомашинд тохиромжтой зам байжээ.

ОЛОН УЛС СУДЛАЛЫН ХҮРЭЭЛЭНГЭЭС СҮҮЛИЙН ЖИЛҮҮДЭД ХЭВЛҮҮЛСЭН НОМУУД.

1.1990-ээд оны олон улсын харилцааны хандлагууд, Монгол улс их гүрнүүдийн харилцаа. «Хүйтэн дайн»-ы эрин төгсгөл болсон сүүлийн жилүүдэд олон улсын харилцаанд зарчмын шинж чанартай өөрчлөлтүүд гарч шинэ тогтолцоонд шилжин хэв загвараас ангижирч, үндэсний эрх ашгийг дээдэлсэн прагматик шинж чанартай болж манай улсын үндэсний эрх ашгийг дээдэлсэн зэрэг Ази, Номхон далайд төдийгүй дэлхийн бодлогод нөлөөтэй улс орнууд тодорхой байр суурь эзлэх болсон болон мөн урд хөршийн бүс нутагт үзүүлэх нөлөө нэмэгдэж байгаатай уялдан Америк-Хятад, Япон-Хятадын харилцаа ч Монголын гадаад орчинд ямар нэг хэмжээгээр учир холбогдолтой болсон юм. Тус номонд Ази, Номхон далайн бүс нутгийн дөрвөн их гүрэн АНУ, БНХАУ, ОХУ, Японыг сонгон авч их гүрэн тус бүрийн бодлого, түүнд илэрч буй шинэ хандлагууд, тэдгээр орнууд ба Монгол улсын харилцаа, ялангуяа хоёр талын харилцаанд 90-ээд онд бий болсон шинэ хүчин зүйлс хоёр талын харилцааг эрчимжүүлэх арга замыг тодорхойлсон байна.

2. Монголын эзэнт гүрний гадаад харилцаа. Энэ номонд Их Монгол улс байгуулагдсанаас эхлэн Монголын эзэнт гүрний төгсгөл үеийг хүртэл Монгол Улсын гадаад харилцааг шинэлэг санаа

бодлоор дүгнэн бичсэн байна. Монголын нэгдсэн төр улс, Чингис хааны угсааныхны байгуулсан Юан улс, Цагаадайн улс, Иль хаадын улс, Алтан ордон зэрэг улс гүрнүүдийн гадаад харилцааг судлан бичсэн энэ бүтээл Ази, Европын улс, түмнүүдийн харилцааны томоохон нэгэн үеийг танин мэдэхэд тус болов. Урьд Ази, Европ дахь Монголын ноёрхлыг бүх талаар харгис үүрэг гүйцэтгэсэн гэсэн ойлголт учир дутагдалтай болохыг харууллаа. Тус номыг академич Н.Ишжамц, дэд доктор С.Дашцэвэл, дэд доктор М.Хурметхан, нар редакторлажээ.

3.Орос дахь Монгол угсааны улсууд. Бүгд Найрамдах Буриад, Халимаг-Тангч, Тува, Алтай улсууд болон буриадын автономит тойргуудын тухай доктор Д.Нямаа, Ч.Батцэцэг нарын бичсэн энэ ном эдгээр улсуудын түүх, угсаа гарал, нийгэм, эдийн засаг болон Монгол улстай ямар харилцаатай байгааг судалгааны ховор чухаг материал ашиглан дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

4.MONGOLIA: Investment environment and opportunities. Дэд доктор Ц.Батбаярын редакторласан энэ ном зах зээлийн системд шилжин орсон манай орны өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн тогтолцоо, хөрөнгө оруулахад холбогдох хууль эрхийн актууд, дэд бүтцийн байдал, гааль, гадаад худалдааны талаар тодорхой мэдлэг олгоход чиглэсэн болно.

5. Хятад дахь монголчууд. дэд доктор Л.Жамсран, Н.Алтанцэцэг, Ч.Эрдэнэбаяр нарын хамтын бүтээл уг ном нь тус хүрээлэнгийн «Хилийн чанад дахь монголчууд» судалгааны чиглэлийн хоёр дахь ном юм. БНХАУ-д бие даасан засаг захиргааны нэгжийн хэлбэрээр оршин буй монголчуудын өвөр монгол, ойрад монгол, зүүн хойт хятад дахь монгол, өмнөд хятад дахь монголчууд/ тухай өгүүлэхдээ Манж Чин гүрний Монгол орныг Ар, Өвөр хэмээн зааглан тусгаарлах бодлогын үеийн Өвөр Монголын байдлаас өнөөг хүртэлх үеийг тодорхой түүхчлэн үзэж, соёлын хувьсгалын үеийн Хэлмэгдүүлэлт, сүүлийн жилүүдэд нийгэм эдийн засгийн амьдралд олсон ололт амжилт, соёл, боловсролыг харан бичжээ.

6. Монгол, Хятад, Япон; орон судлалын өгүүлүүд. дэд доктор Ц.Батбаярын уг ном түүний сүүлийн жилүүдэд бичсэн өгүүлүүдийн түүвэр болно. Өгүүлүүд нь дээрх орон судлалын улс төр, эдийн засаг, гадаад харилцааны асуудлыг хөндсөн байна. Монгол судлалын өгүүлүүд нь манай орны өнөөгийн улс төрийн өөрчлөлт, шинэчлэлийг тус орны гадаад, дотоод нөхцөл байдалтай уялдуулан дүгнэж бичсэнээс гадна Монгол улсын хамтын ажиллагааны цаашдын төлөвийг Зүүн Хойт Ази болон Төв Азийн бүс нутгийн орнуудын хүрээнд судлан бичжээ.

7. Өнөөгийн Хятад орон. Монгол, Хятад хоёр орны харилцаа сэргэн буй өнөө үед манай уншигч олон хөрш орныхоо тухай илүүтэй мэдэх шаардлага нэмэгдсэнтэй уялдан Н.Алтанцэцэг,

Д.Шүрхүү, Л.Лхамдулам, Д.Түвшин нарын бичсэн энэ ном Хятад орны түүх, улс төрийн байгуулал, эдийн засгийн шинэчлэл, шинжлэх ухаан, соёл, нийгмийн амьдрал, Монгол-Хятадын харилцааг хамран товч лавлахын хэлбэрээр бичигдсэн болно. Мөн Хятад руу зорчих хүсэлтэй уншигчдад зориулсан Бээжингийн зочид буудал, зах, дэлгүүр, үзвэрийн газрууд болон Хятад руу явах онгоц, галт тэрэгний цагийн хуваарь, гааль, Визийн талаарх мэдээлэл, Хятадад очиж суралцагсдад зориулсан зөвлөмж, хятад-монгол товч толийг багтаасан байна.

8.ОХУ-ын БН Буриад Улс. Ч.Батцэцэгийн бичсэн энэ ном хөрш Буриад улсын өнөөгийн бүх талыг хамарсан товч лавлах ном юм. Өнөөдөр угсаа гарваль нэгтэй хөрш улстайгаа ойртож, тэдгээрийн өөрчлөлт, шинэчлэлийн туршлагатай танилцаж, соёл, экологи, хүмүүнлэгийн салбарт хамтран ажиллах явдал зүй ёсны шаардлагатай болж байгаа учир энэ ном тус улсын талаар манай ажил хэрэгч хүмүүст хэрэгтэй мэдээллийг өгөх болно.

9. «The Mongolian journal of international affairs» хэмээх сэтгүүлийг англи хэл дээр 1994 оноос эхлэн жил тутам гаргаж байгаа бөгөөд үүнд Монгол орны өнөөгийн улс төр эдийн засгийн байдал, бүс нутаг, олон улсын харилцааны зарим чухал асуудлыг хөндөн бичсэн өгүүллүүд хэвлэгдэж байна.

10.»Дорно Өрнө» сэтгүүл жил тутам хоёр дугаар хэвлэгдэж Олон улсын харилцаа, Монгол Улсын гадаад бодлого, эдийн засгийн хамтын ажиллагаа, монголын түүх, эдийн засгийн шинэ судалгааг тогтмол хэвлэн нийтэлж байна.

Д.Түвшин.

МОНГОЛ УЛС ГАДААДТАЙ ХАРИЛЦСАН ГОЛ ҮЙЛ ЯВДЛЫН
ЖАГСААЛТ /1996 оны эхний хагас/

1996.01.08-10. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй УИХ-ын төлөөлөгчид БНЭУ-ын парламентын урилгаар албан ёсны айлчлал хийлээ.

1996.01.20-23. Монгол Улсын Их Хурлын дарга Н.Багабанди тэргүүтэй төлөөлөгчид Тайландын Вант улсын парламентын урилгаар Тайланд улсад албан ёсны айлчлал хийв.

1996.01.29-02.03. ШУБ-ын сайд С.Төмөр-Очир тэргүүтэй боловсролын байгууллагын төлөөлөгчид БНХАУ-ын Дээд Боловсролын хорооны урилгаар БНХАУ-д албан ёсны айлчлал хийж,